

Юнаний Монголчууд (тэмдэглэл)

Академич Ж.Болдбаатар

Өвөр Монголын нэрт эрдэмтэн Чимэддоржийн урилга, тэтгэлэгээр 2009 оны VII сарын 27-31-нд БНХАУ-ын Юнань мужийн Кунмин хотноо болсон Хүн судлал, угсаатны зүйн ухааны олон улсын холбооны XVI конгресст оролцлоо. Энэ хуралд 4300 гаруй эрдэмтэн судлаачид оролцсоны 1000 гаруй нь харь орны зочид байв. Монголоос академич Д.Төмөртоогоо, доктор (Sc.D), профессор С.Дулам, доктор Долгосүрэн, Дашцэвэл, Ц.Цэцэнбилэг, П.Дэлгэржаргал, Д.Бум-Очир, Лхам зэрэг эрдэмтэд оролцлоо.

П.Дэлгэржаргал бид хоёрын хувьд “Түүх болон түүхийн дурсамж дахь нүүдэлчдийн соёл” сэдэвт салбар хуралдаанд илтгэл тавив. Би “Монгол хуврагын амьдрал” (XIX зууны II хагасаас XX зууны эхэн үе) сэдэвт илтгэл тавив. Энэхүү илтгэлд: өмнөх тогтолцоонд шашин, лам нарын асуудлыг дан сөрөг талаас нь тайлбарлаж байсанд няцаалт өгч, тухайн цагийн монголын нийгмийн амьдралд лам нарын үзүүлсэн эерэг нөлөө, тэдний нийгэмд эзэлж буй байр суурь, ахуй байдал, төрх төлөвийг тодорхойлон гаргасан болой.

Кунмин хот 4 сая орчим хүн амтай, цаг уурын хувьд зөөлөн чийглэг уур амьсгалтай, их төлөв 20-25 хэм халдаг аж. Ийм учраас мөнхийн хаврын хот хэмээх алдартай.

Бид Юнанийн монголчуудын гацаанд зочлов. Эндэхийн монголчууд монгол хэлээ үндсэндээ мартсан. Янз бүрийн ястан, үндэсний холимог казу хэлийг үүсгэсэн. Тэдний үзэж байгаагаар Казу хэлний 10 орчим хувьд монгол үг байдаг гэнэ. Одоо хүртэл тэд чихийг навч, тамхийг тамхи гэж хэлж, хамаагүй гэсэн монгол үгийг байн байн хэрэглэнэ. Тэд хэлээ монгол үндэсний казу хэл гэж нэрлэдэг байна.

Мөнх хаан Сүн улсыг бүрэн дайлан авахаас өмнө 1253 онд Хубилай 10 мянган монгол цэрэгтэй энд иржээ. Тэр цагаас Юнаний өндөрлөгт суурьшаад 700 гаруй жил болсон. Мин улс байгуулагдсанаас хойш 10 гаруй жил өөрийн засаглалаа хэвээр хадгалж байжээ. Мин улс монголчуудыг 30 мянган цэрэг илгээж, мөрдөж мөшгөж, алж талж байсан боловч, уул хадаар зугатан нуугдаж, үндэс угсаа, нэр усаа нууж, амьд мэнд гарсан цөөн монголчууд өдгөө үлджээ. Тэд бидний өвөг дээдэс гал, усны гашуун зовлон туулж, үндэс угсаагаа авч үлдсэн хэмээн гацааны дарга, ноён овог Гуан хэмээх залуу ярьсан юм. Энэ гацаа 1988 онд өөртөө засах эрхтэй болжээ.

Энэ гацааны нэг иргэн 1957 онд Ю.Цэдэнбал даргад захиа бичиж, энд хэсэг монгол хүн байгааг мэдэгджээ. Чингээд түүхч, хожмын академич Ш.Нацагдоржийг энэ газар томилон ирүүлсэн байна. Ийнхүү Ш.Нацагдорж багш XX зуунд алс газар таслагдсан монголчууд руугаа ирсэн анхны монгол хүн болжээ.

Өвөр Монголчуудтайгаа холбоо тогтоож, 1957 онд дөрвөн залууг явуулж монгол хэл сургажээ. Тэдний нэг Сэргэлэн гуай амьд сэрүүн, ануухнаараа төдийгүй ойр зуур монголоор ярьж байлаа.

Одоо энэхүү гацаа таван тосгоноос бүрдэн, 5600 орчим хүн амтай. Хэл, соёл нь нэлээд бүдгэрсэн боловч, монголоо гэсэн сэтгэлгээтэй, монгол хүн гэдгээрээ ямагт бахархдаг аж. Эл гацаа далайн түвшинээс 1800 м өндөрлөгт оршдог. Эхэн үедээ нууранд завиар загасчилж амьдардаг байсан. Эдүгээ амтат гуа тарьдагаараа

VI. ТҮҮХЭН БАРИМТ БИЧИГ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭ

алдартай. Бас бага, дунд хэмжээний маш өвөрмөц барилга барьдаг. Нэг иргэний жилийн дундаж орлого 4000 гаруй юань. Өдгөө үр хүүхдээ Шилийн гол зэрэг газар явуулж, монгол хэл сургаж байгаа гэнэ. Монгол хувцасны зарим нэг бүрдэл орсон цамц өмсдөг.

Юнаний монголчууд Монголын түүх, соёлын үзэсгэлэн байгуулах, аялал жуучлалыг хөгжүүлэх эрмэлзлэлтэй. Үзэсгэлэнгийн барилгаа монгол үндэсний хэлбэртэй барихаар төлөвлөж байна. Энэ хэрэгтээ нийт монгол туургатнаас тусламж хүсч байгаа юм байна. Эл хэрэгт тусламж үзүүлэхийг хүсч буй монгол хүн харьцах боломжтой. Юнаний өндөрлөгт бидний мах цусны тасархай, монгол сэтгэлгээтэй, монгол үндсээ хадгалахыг чин сэтгэлээсээ эрмэлзсэн цөөн хүн байна шүү. Монголоо гэсэн хүн бүхэн анхааран, түүх, соёлын үзэсгэлэнг байгуулахад нь нэмэр хандив өргөвөл зүгээрсэн.

Бид бас Кумин хотоос холгүй орших “Чулуун ой” үзлээ. Энэ үнэхээр чулуун ой ургасан мэт огцом огцом хадтай, гайхамшигтай үзэсгэлэнтэй газар ажээ.